



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Л.Нарантуяа нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тул “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ